

2024 оны 01 сарын 29-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

***“Итгэлцлийн үйлчилгээний журам”
шинэчлэн батлах тухай***

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.4 дэх хэсэг, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.17, 8.11 дахь хэсэг, Компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.6.3, 11 дүгээр зүйлийн 11.8 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 434 тоот тогтоолоор батлагдсан “Итгэлцлийн үйлчилгээний журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Компанийн “Итгэлцлийн үйлчилгээний журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/, Эрдэдэл, хяналт шалгалт хариуцсан захирал /Д.Баярбат/ нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбоотойгоор Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/10 тоот тушаалын 5 дугаар хавсралтыг хүчингүйд тооцсугай.
4. Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАНБАТ






ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Иргэний хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Итгэлцлийн үйлчилгээний журам”-д нийцүүлэн “Сэндли Банк бус санхүүгийн байгууллага /цаашид “ББСБ” гэх/-аас итгэлцлийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор итгэмжлэгч болон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Итгэлцлийн үйл ажиллагаа нь итгэх, үнэнч байх, эрх тэгш, шударга байх, хариуцлага тооцох зэрэг үндсэн зарчмуудад үндэслэнэ.

ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

- 2.1. “Итгэмжлэгч” гэж өөрийн бэлэн мөнгө, зээл, бусад активыг итгэмжлэгдэгчийн удирдлагад шилжүүлж, түүнээс гарах үр шимийг өөрөө хүртэх, эсхүл хувь хүртэгчид хүртээх зорилго бүхий иргэн, хуулийн этгээдийг.
- 2.2. “Итгэмжлэгдэгч” гэж итгэмжлэгчээс хүлээн авсан бэлэн мөнгө, зээл, бусад активыг түүнтэй байгуулсан хөрөнгө итгэмжлэх гэрээний дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах үүрэг хүлээсэн, итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий ББСБ-ыг.
- 2.3. “Итгэлцлийн үйлчилгээ” гэж итгэмжлэгчийн бэлэн мөнгө, зээл, бусад активыг үнэгүйдлээс хамгаалж, ашиг /үр шим/ олж өгөх зорилгоор тэдгээртэй харилцан тохиролцож хөрөнгө итгэмжлэх гэрээг байгуулж, актив хөрөнгийг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан зохицуулагч байгууллагаас олгосон зөвшөөрлийн хүрээнд удирдахыг,
- 2.4. “Хувь хүртэгч” гэж итгэмжилсэн хөрөнгийн ашиг /үр шим/-ийг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүртэхээр хөрөнгө итгэмжлэх гэрээнд заасан гуравдагч иргэн, хуулийн этгээдийг.
- 2.5. “Итгэмжилсэн хөрөнгө” гэж итгэмжлэгчээс итгэмжлэгдэгчид хөрөнгө итгэмжлэх гэрээний дагуу шилжүүлэн өгсөн бэлэн мөнгө, зээл, бусад активыг.
- 2.6. “Хөрөнгө итгэмжлэх гэрээ” гэж Иргэний хуулийн 406 дугаар зүйл болон энэ журамд заасныг удирдлага болгон итгэмжлэгч, итгэмжлэгдэгчийн хоорондын бичгээр үйлдсэн тохиролцоог.
- 2.7. “Итгэлцлийн үйлчилгээний нөхцөл” гэж итгэмжилсэн хөрөнгийн хэмжээ, захиран зарцуулах хугацаа, үр шимийн хувь хэмжээг,

ГУРАВ. ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- 3.1. Итгэлцлийн үйлчилгээний нөхцөл:
 - 3.1.1. Итгэлцлийн үйлчилгээний нөхцлийг ББСБ-ын Гүйцэтгэх захирлын тушаалаар батална.
 - 3.1.2. Итгэмжлэгчийн хөрөнгийг итгэлцлийн үйлчилгээний хүрээнд хянах, ашиглах, захиран зарцуулах доод хугацаа зургаан сараас доошгүй байх;
 - 3.1.3. Үр шимийн хувь хэмжээг аливаа хэлбэрээр олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглан түгээхгүй бөгөөд зөвхөн өөрсдийн харилцагч дунд хаалттай хүрээнд зарлаж болно;

- 3.2. Итгэлцэлийн үйлчилгээ үзүүлэхэд баримтлах зарчим:
- 3.2.1 Итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч нь итгэмжлэгчтэй байгуулсан Хөрөнгө итгэмжлэх гэрээний дагуу тэдгээрийн актив хөрөнгийг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан зохицуулагч байгууллагаас олгосон зөвшөөрлийн хүрээнд удирдах бөгөөд бусад үйл ажиллагаанд зарцуулахгүй байх;
 - 3.2.2 Итгэмжлэгдэгчийн гүйцэтгэх удирдлага нь тухайн ББСБ-ын цорын ганц хувь нийлүүлэгч биш тохиолдолд итгэлцлийн үйлчилгээгээр хүлээн авсан хөрөнгийн хэмжээ, хөрөнгө итгэмжлэх гэрээгээр хүлээсэн үүрэг, хариуцлагын талаар бусад хувь нийлүүлэгчдэд мэдэгдэх;
 - 3.2.3 Итгэмжилсэн хөрөнгийг Хөрөнгө итгэмжлэх гэрээгээр тогтоосон нөхцлийг зөрчиж хувь хүртэгчийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;
 - 3.2.4 Харилцагч татах зорилгоор бэлэг эсхүл бусад урамшуулал санал болгохгүй байх;
 - 3.2.5 Харилцагчийг хүүгийн зөрүүнээс ашиг олох зорилгоор итгэлцлээр хөрөнгө байршуулахыг ятгахгүй байх;
 - 3.2.6 Өөрийн үйл ажиллагааны үр дүнг худал мэдээлэх, харилцагчийн хувийн мэдээлэл задруулах болон төөрөгдөлд оруулахуйц үйлдэл гаргахгүй байх;
 - 3.2.7 Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олон нийтэд тараах материал болон итгэлцлийн үр шимийн үнэ цэний баталгаа болгон ашиглахгүй байх;
 - 3.2.8 Хөрөнгийн үндсэн дүнгийн найдвартай байдал, эсхүл үр шим олно гэдэгт баталгаа гаргах болон баталгаа гаргасан мэтээр бусдыг төөрөгдүүлэхгүй байх;
 - 3.2.9 Итгэмжлэгчийн хүсэл зоригийн эсрэг өөрсдийн нөхцөл, шаардлагыг тулгасан Хөрөнгө итгэмжлэх гэрээ байгуулахыг итгэмжлэгчээс шаардахгүй байх;
 - 3.2.10 Гэрээгээр тохирсон тохиолдолд итгэмжлэгдсэн хөрөнгийг захиран зарцуулах үйл ажиллагаатай холбогдох бүртгэл, тайлан болон бусад шаардсан мэдээллийг итгэмжлэгчид үнэн зөв гаргаж өгөх;
 - 3.2.11 Итгэмжлэгчээс шилжүүлэх мөнгөн хөрөнгийн гарал үүслийг тодорхойлсон байх.
 - 3.2.12 Итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч нь итгэмжлэгдсэн хөрөнгийн эрсдэлийг бууруулах зорилгоор тухайн хөрөнгийг даатгуулах, эсхүл гуравдагч этгээдээр үүргийн гүйцэтгэл хангуулах баталгаа гаргуулж болно.

ДӨРӨВ. ТАЙЛАГНАЛ

- 4.1. Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтмол хангаж ажиллана;
- 4.2. Сар бүрийн 10-ны өдрийн дотор энэхүү журмын хавсралтын дагуу гаргасан итгэмжилсэн хөрөнгийн тайлан судалгаа, ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн дагуу санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг гаргаж улирал бүр Санхүүгийн зохицуулах хороонд цаасаар болон цахимаар хүргүүлэх;

ТАВ. ИТГЭМЖЛЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 5.1. Итгэмжлэгч нь дараах шаардлагыг хангасан байна.
 - 5.1.1. Эрх зүйн бүрэн чадамжтай иргэн, хуулийн этгээд байх;
 - 5.1.2. Итгэлцлийн үйлчилгээг авах зорилгоор ББСБ-ын санхүүгийн болон бусад шаардлагатай мэдээлэлтэй танилцсан байх;
 - 5.1.3. Итгэмжлэгч нь өөрийн эрсдэлээ ухамсарлаж итгэлцлийн үйлчилгээг авах эсэх шийдвэрээ бие даан гаргах;
 - 5.1.4. Итгэмжилсэн хөрөнгө нь хууль ёсны байх;

ЗУРГАА. ИТГЭМЖЛЭГЧИЙН БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

- 6.1. Итгэмжлэгч нь дараах дараах материалыг бүрдүүлнэ.
 - 6.1.1. Иргэний хувьд:
 - 6.1.1.1. Иргэний үнэмлэх;
 - 6.1.1.2. Анкет; /хавсралт 1/
 - 6.1.2. Хуулийн этгээдийн хувьд:
 - 6.1.2.1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
 - 6.1.2.2. Хуулийн этгээдийн дүрэм;
 - 6.1.2.3. Гүйцэтгэх захирлын иргэний үнэмлэх;
 - 6.1.2.4. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилсон шийдвэр, итгэмжлэл;
 - 6.1.2.5. Эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл;
 - 6.1.2.6. Анкет; /Хавсралт 2/
 - 6.1.3. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нэмэлтээр гаргуулан авсан бусад бичиг баримт;

ДОЛОО. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭХ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- 7.1. ББСБ болон итгэмжлэгч харилцан тохиролцсоны үндсэн дээр Хөрөнгө итгэмжлэх гэрээг бичгээр, эсхүл хуульд заасны дагуу цахим хэлбэрээр байгуулна.
- 7.2. Хөрөнгө итгэмжлэх гэрээнд хуульд зааснаас гадна дараах зүйлийг заавал тусгана:
 - 7.2.1. гэрээ байгуулсан огноо, гэрээний дугаар;
 - 7.2.2. Итгэмжлэгч, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгчийн овог нэр, иргэний бүртгэлийн дугаар, хаяг, утас;
 - 7.2.3. Итгэмжлэгчээс итгэлцлийн үйлчилгээ эрхлэгчид шилжүүлэх хөрөнгийн төрөл, нэр, хэмжээ, үнэ цэнэ, гэрээний хугацаа;
 - 7.2.4. Итгэмжлэгдсэн хөрөнгийг захиран зарцуулах зориулалт;
 - 7.2.5. Итгэмжлэгчийг итгэлцлийн үйлчилгээтэй холбогдох мэдээллээр хэрхэн хангах тухай;
 - 7.2.6. Итгэмжлэгч болон ББСБ-ын эрх, үүрэг, хүлээх хариуцлага;
 - 7.2.7. Гэрээ дуусгавар болоход итгэлцлийн хөрөнгийг хэрхэн хөрвүүлж, итгэмжлэгчид шилжүүлэх тухай;
 - 7.2.8. Хувь хүртэгч байгаа тохиолдолд түүний эрх, үүрэг, хүлээх хариуцлага, хүртэх үр шим, хэмжээ, хугацаа;
 - 7.2.9. Итгэмжлэгч нь гуравдагч этгээдэд хөрөнгө итгэмжлэх гэрээний шаардах эрхийг шилжүүлэх тохиолдолд Иргэний хуулийн 123 дугаар зүйлд заасны дагуу шилжүүлэх;

НАЙМ. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД ТУСГАХ

- 8.1. Итгэлцлийн үйлчилгээтэй холбоотой гүйлгээг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн заавар”-д заасны дагуу хийж гүйцэтгэж, нягтлан бодох бүртгэлд бүртгэнэ.

ЕС. ХУВИЙН ХЭРГИЙН БҮРДҮҮЛБЭР БОЛОН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ

- 9.1. Бүртгэл хийсэн ББСБ-ын ажилтан нь хөрөнгө итгэмжлэх гэрээний дугаар, болон огнооны дагуу хувийн хэрэг үүсгэж хувийн хэргийн хадгалалт хамгаалалтыг хариуцна.
- 9.2. Хувийн хэрэг дараах баримт бичгээс бүрдэнэ.
 - 9.2.1. Энэхүү журамд заасны дагуу итгэмжлэгчээс бүрдүүлсэн бүх бичиг баримт
 - 9.2.2. Хөрөнгө итгэмжлэх гэрээ
 - 9.2.3. Хөрөнгө итгэмжлэх гэрээний дагуу хийсэн төлбөр тооцооны баримт
 - 9.2.4. Гэрээ байгуулснаас хойш бүрдүүлсэн бусад баримт бичиг

АРАВ. ХЯНАЛТ ХАРИУЦЛАГА

- 10.1. Итгэмжилсэн хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулж, хөрөнгө итгэмжлэх гэрээнд заасны дагуу хувь хүртэгч /хүртэгчид/-д ашиг /үр шим/ ногдож байгаа эсэхэд Дотоод хяналт шалгалт хариуцсан нэгж хяналт тавьж ажиллана.
- 10.2. Итгэлцлийн үйлчилгээг эрхлэхдээ энэхүү журмыг зөрчсөн нь холбогдох хуулийн хариуцлага хүлээлгэхээргүй бол ББСБ-ын ажилтанд Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 10.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай болон бусад хууль тогтоомж, ББСБ-аас гаргасан журмыг мөрдөөгүйгээс үүссэн хохирол, итгэлцлийн үйлчилгээтэй холбоотой гарсан аливаа маргааныг хөрөнгө итгэмжлэх гэрээ болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хууль сахиулах байгууллагаар шийдвэрлүүлнэ.



Анкет /иргэн/

"Итгэлцлийн үйлчилгээний журал"-ын Хавсралт 1



1 ХАРИЦАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Ургийн овог: _____ Иргэний бүртгэлийн дугаар: _____

Эцэг/эх/-ийн нэр: _____ Гэрлэлтийн байдал: _____

Нэр: _____

Иргэний үзэмж/хүйс хаяг: _____

Оршин суугаа хаяг: _____

Утас: _____ Факс: _____ Гар утас: _____ И-Мэйл: _____

2 БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Д/д	Хаана ямар сургууль төгссөн	Элсэн огноо	Төгссөн огноо	Эгэмшсэн мэдэгдэл

3 ГЭР БУЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Д/д	Овог нэр	Таны юу болох	Хяна юу хийдэг	Регистрийн дугаар	Холбоо барих утас

4 АЖИЛ ЭРХЛЭЛТ

Д/д	Байгууллагын нэр	Ажилд орсон огноо	Үйл ажиллагааны чиглэл	Албан тушаал

6 ҮЙДЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

Итгэмжлэх хөрөнгийн хэмжээ: _____ Итгэлцлийн үйлчилгээний нөхцөлтэй танилцаж бүрэн ойлголт авсан эсэх: Тийм Тийм

1.1	Итгэмжлэх хөрөнгийн гарал үүсэл?	Үл хөдлөх, хөдлөх хөрөнгө худалдан борлуулсан
1.2	Бусад орлого бол нэмэлт тайлбар /Швардагатай тохиолдолд/	

ХАРИЦАГЧИЙН ЗӨВШӨӨРӨЛ МЭДЭЭГДЭЛ

А. Харилцагчийг таних мэдээлэл нугауулах тухай:

Миний бие ББСБ-ийн ажилтанд өөрийн баримт бичгийг огч зориулалтын төхөөрөмжид хурууны хэргээ уншуулах замаар намайг таних мэдэх мэдээллийг холбогдох байгууллага, "ХУР" төрийн мэдээллийн систем, Монголбанкны Зээлийн мэдээллийн сан, аппликейшид оруулсан мэдээлэл зэргээс татаж авах, хадгалах, хуульд заасан арга хэлбэрээр ашиглахыг ББСБ-д зөвшөөрч байна.

Б. Улс төрд нөлөө бүхий этгээдийн мэдээлэл:

Удирдлага, хувь эзэмшигч болон түүнтэй хамаарал бүхий этгээд нь Улс төрд нөлөө бүхий этгээд мөн эсэх Тийм Үгүй

Ямар хамааралтай болох	Овог нэр	Эрхэлж буй ажил, албан тушаал

*Улс төрд нөлөө бүхий этгээд гэж МУ-ын Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн, МУ-ын Ерөнхий сайд, ЗГ-ын гишүүн, Үндсэн хуулийн цэцгийн гишүүн, УДШ-ийн Ерөнхий шүүгч, УДШ-ийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, УИХ-д ажлаа шууд харууцан тайлагнадаг байгууллагын дарга, Аймаг нийслэлийн Засаг дарга, Аймаг, нийслэлийн ИТХурлын тэргүүлэгчдийн дарга, яамны төрийн нэрийн бичгийн дарга, ЗГ-ын агентлагийн дарга, төрийн өмчит компанийн дарга, захирал, гадаад орны төрийн тэргүүн, ЗГ-ын тэргүүн, улс төрийн болон ЗГ, шүүх, цэрэг армийн өндөр албан тушаалтан, төрийн өмчит аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан, улс төрийн намын удирдлагад багтдаг хүн, ОУ-ын байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн, дарга, захирал, орлогч захирлын албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүнийг ойлгоно

В. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай

Миний бие мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааг дэмждэггүй, санхүүжүүлдэггүй бөгөөд өөрийн аппликейшид дэх мөнгөн хөрөнгөтэй холбоотой дараах баталгааг огч байна.

- Эх үүсвэр нь хууль ёсны дагуу бүрдсэн
- Мөнгөн хөрөнгө нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд зарцуулагдахгүй, аливаа хэлбэрээр хамааралгүй болохыг баталж байна.

Энэхүү анкетанд үнэн зөв мэдээлэл, тоо баримт бичсэн болно.

гарын үсэг

Он

Сар

Өдөр

АЖИЛТАНЫ БӨГЛӨХ ХЭСЭГ

Анкет хүлээн авсан огноо _____

Салбар тэгж _____

Тэмдэглэл: _____



ХАРИЦАГЧИЙН АНКЕТ /Хуулийн этгээд/

Анкет хүлээн авсан огноо (Ой/ар/болоор)

Ажилтан

ХАРИЦАГЧИЙН ТАЛААРХ НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Хуулийн этгээдийн нэр:	<input type="text"/>	Регистр:	<input type="text"/>
Урьдчилсан бүртгэлийн дугаар	<input type="text"/>	Байгууллагын огноо:	<input type="text"/>
Нийт хувьцааны тоо	<input type="text"/>	Нийт хувьцааны дүн	<input type="text"/>
Удирдлагын нэр:	<input type="text"/>	Албан тушаал	<input type="text"/>
Холбоо барих:	<input type="text"/>	Утас 2	<input type="text"/>
Утас 1	<input type="text"/>	И-мэйл	<input type="text"/>
Факс:	<input type="text"/>		

Оршин суугаа хаяг:

Байгууллагын албан ёсны хаяг:

Хуульч эзэмшигчийн таларх мэдээлэл

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Нийт хувьцаанд эзлэх хувь	Регистр	Хяна ажлаадаг, сурдаг болсон гэмэр, сургууль, төлгөлт	Утас
1					
2					
3					
4					
5					
6					

Үйл ажиллагааны таларх мэдээлэл

№	Бизнесийн төрөл	Хийг	Үйл ажиллагаа эрхлэсэн хугацаа
1			
2			

Үйлчилгээний төлөв:

Итгэмжлэх хөрөнгийн хэмжээ: Итгэмжлэх үйлчилгээний нөхцөлгүй талшицаж бүрэн олголт авсан эсэх: Тийш

1.1	Итгэмжлэх хөрөнгийн гарал үүсвэл	Үйл хэргийг хэрэгжүүлэх хөрөнгө худалдан борлуулал
1.2	Бусад орлого бол нэмэлт талбар /Шардлагагүй тохиолдолд/	

Хуулийн этгээдийн хувьд:

Хуулийн этгээд бол төлөөрлөгч	Хариуцагч
1 Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч тогтоох. Хэдэн хүнтэй вэ?	
2 Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч удирдлагын мэдээллийг үг хөдөөрхөөр дамжуулан авсан эсэх.	Үгүй
3 Хуулийн этгээд хяналт тогтоож буй этгээдийг тогтоох. Хяналт тогтоож буй хүний тоо хэд вэ?	

Харилцагчийн зөвлөснөөр, мэдээлэл

1. Харилцагчийг таних мэдээлэл цуглуулах тухай:

Миний бие БСБС-ийн ажилтан; оршин бичигт бичгийн өгч заруулагчын төлөөрхөөр хуульч эзэмшигчээр үйлчилж байгаа бөгөөд мэдээллийг мэдээлж байгаагүйг, "ХУР" төрийн мэдээллийн систем, Монголбанкны Эцсийн мэдээллийн сан, ашигласнаар оруулсан мэдээлэл зөвхөн хэргийн хяналтын, хуульч эзэмшигч өргө хэрэгээр ашиглахыг БСБС-д зөвшөөрч байна.

2. Уас төрд нөлөө бүхий этгээдийн мэдээлэл:

Удирдлага, хувь эзэмшигч болон түүнтэй хамаарал бүхий этгээд нь: Уас төрд нөлөө бүхий этгээд мөн эсэх Тийш Үгүй

Ямар хэмжээтэй болох	Огноо нэр	Эрхэлж буй ажил, албан тушаал

*Уас төрд нөлөө бүхий этгээд тэр: МУ-ын Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн, МУ-ын Ерөнхий сайд, ЗГ-ын гишүүн, Үндсэн хуулийн цэврийн гишүүн, УДШ-ийн Ерөнхий нүүгч, УДШ-ийн нүүгч, Улсын ерөнхий прокурор, УИХ-д ажлаа гэрээ хэрэггүйг тайлж байгуулагчын дарга, Албан таслагчийн Засаг дарга, Албан таслагчийн ИГХураан тэргүүлэгчийн дарга, хэлтэс төрийн шүүхийн дарга, ЗГ-ын ажиллагчийн дарга, төрийн өмчтэй компанийн дарга, захирал, талвад орны төрийн тэргүүн, ЗГ-ын тэргүүн, улс төрийн болон ЗГ, шүүх, иргэд арийн өндөр албан тушаалтан, төрийн өмчтэй аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан, уас төрийн нэмэн удирдлагад бөтөлөг хүч, ОУ-ын байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн, дарга, захирал, орлогч захиралын албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүнийг ойлгоно

3. Манго угаах болон терроризмыг санхүүжүүлэх тэмцэх тухай

Миний бие манго угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааг дэмжсэнтэй, санхүүжүүлэггүй бөгөөд өөрийн ашигласнаар дэх мэдээлэл хөрөнгөтэй холбоотой дараах баталгааг өгч байна.

- Эх үүсвэр нь хууль бусаг дагуу бүрдсэн
- Монгол хөрөнгө нь манго угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд зарцуулагдгүй, аливаа хэлбэрээр хамааралгүй болохыг баталж байна.

Эцэстүү ашигласнаар үнэн зөв мэдээлэл, төв баримат бичсэн байна.

<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>
Харилцагч	Гарын үсэг	Огноо
<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>
Ажилтан	Гарын үсэг	Огноо

Тэмдэглэл:



ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭХ ГЭРЭЭ

202.. оны .. дүгээр сарын ..

№ ИГ.....

Улаанбаатар хот

Энэхүү “Хөрөнгө итгэмжлэх гэрээ” (цаашид “Гэрээ” гэх)-г Монгол Улсын Иргэний хууль, Банк бус санхүүгийн байгууллагын тухай хуулийг тус тус үндэслэн,

Нэг талаас Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 2-р хороо, Бакула рембүчи гудамж 8/4 тоот , хаягт орших 5961548 тоот регистрийн дугаартай “Сэндли” ББСБ”ХК-г төлөөлж (цаашид “ББСБ эсхүл Итгэмжлэгдэгч” гэх),

Нөгөө талаас тоот хаягт орших, иргэний бүртгэлийн дугаартай -ийг төлөөлж овог нэр..... (цаашид “Итгэмжлэгч”, хамтад нь “Талууд” гэх) нь ББСБ-аас санал болгосон үйлчилгээний ашиг, хугацааг хүлээн зөвшөөрч дор дурдсан нөхцлүүдийн талаар харилцан тохиролцож байгуулав.

“Санхүүгийн зохицуулах хороо итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон нь тухайн ББСБ-ын итгэлцлийн үр шимийн үнэ цэний баталгаа болохгүйг анхаарна уу.”

Нэг. Гэрээний зүйл

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь ББСБ итгэмжлэгчийн хүсэлтээр мөнгөн хөрөнгийг нь эзэмших, ашиглах захиран зарцуулах, харилцагчид эргүүлэн гэрээнд заасны дагуу ашгийн хамт өгөх болон талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Гэрээнд хэрэглэгдсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.2.1 “Харилцагчийннийн бичиг баримт” гэж харилцагч-компани бол улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, эрх бүхий албан тушаалтны иргэний үнэмлэх, харилцагч- иргэн бол иргэний үнэмлэх болон гадаад паспорт , гадаадын иргэн бол тухайн улсын иргэний үнэмлэх, паспорт г.м харилцагчийг бүрэн илэрхийлж чадах баримт бичгийг;
 - 1.2.2 “Итгэлцлийн үйлчилгээ” итгэмжлэгчийн бэлэн мөнгө, зээл, бусад активыг үнэгүйдлээс хамгаалж, ашиг олж өгөх зорилгоор тэдгээртэй харилцан тохиролцож байгуулсан хөрөнгө итгэмжлэх гэрээний үндсэн дээр итгэмжлэгдэгчээс гэрээнд заасан хугацаанд хянах, ашиглах, захиран зарцуулах үйл ажиллагааг;
 - 1.2.3 “Итгэмжлэгч” гэж өөрийн хөрөнгийг итгэмжлэгдэгчийн удирдлагад шилжүүлж, түүнээс гарах үр шимийг өөрөө, эсхүл хувь хүртэгчид хүртээх зорилго бүхий иргэн, хуулийн этгээдийг;
 - 1.2.4 “Итгэмжлэгдэгч” гэж итгэмжлэгчээс хүлээн авсан хөрөнгийг түүнтэй байгуулсан хөрөнгө итгэмжлэх гэрээний дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах үүрэг хүлээсэн ББСБ-ыг;
 - 1.2.5 “Итгэмжилсэн хөрөнгө” гэж итгэмжлэгчээс итгэмжлэгдэгчид хөрөнгө итгэмжлэх гэрээний дагуу шилжүүлэн өгсөн бэлэн мөнгө, зээл, бусад активыг;

Хоёр. Итгэмжлэгдсэн хөрөнгөнд ашиг тооцох

- 2.1 Итгэмжлэгч нь өөрийн итгэмжлэн өгсөн мөнгөн хөрөнгийг дараах нөхцөлтэй ашиг (үр шим)хүртэхээр тохиров.
 - 2.1.1 Хэмжээ:- /...../ төгрөг

- 2.1.2 Хугацаа: - /...../ сар
- 2.1.3 Үр шим: - Жилийн –% /.... хувь/
- 2.2 Итгэмжлэгч дараах нөхцлөөр тооцоо хийнэ.
- 2.2.1-д заасан мөнгөн хөрөнгийг оны .. сарын ..-ны өдрийн дотор ББСБ-д шилжүүлнэ.
- 2.2.1 Итгэмжлэгч 2.1.3-т зааснаар тооцсон үр шимийг мөнгөн хөрөнгөөр авна.
- 2.3 Үр шим бодох хугацаа нь итгэмжлэгч тал мөнгөн хөрөнгөө байршуулсан үеэс эхлэн энэхүү гэрээ дуусах хүртэл хугацаанд үргэлжилнэ.
- 2.4 Итгэлцлийн үйлчилгээний үр шимийг итгэмжлэгч талд энэхүү гэрээний хугацааны эцэст мөнгөн хөрөнгийг олгосноор тооцно.
- 2.5 Итгэмжлэгч гэрээ дуусгавар болохоос өмнө ажлын 5 өдрийн дотор ББСБ-д ирж, гэрээг шинэчлэх буюу хугацаа сунгуулах өөрчлөлтийн талаар ББСБ-д мэдэгдэнэ.
- 2.6 Итгэмжлэгч ББСБ-тай байгуулсан гэрээний хугацаа дуусахад шууд үргэлжлүүлэн сунгагдаж байхаар хүсэлт гаргасан бол ББСБ хүсэлтийг бичгээр авч, гэрээг итгэмжлэгчийн хүсэлтийн дагуу сунгалт хийнэ.
- 2.7 Итгэмжлэгч гэрээг хугацаанаас өмнө цуцлах эрхгүй ба энэ талаар ББСБ-тай ямарваа нэгэн маргаан гаргахгүй болно.

Гурав. ББСБ-ын эрх, үүрэг

- 3.1 Итгэлцлийн үйлчилгээг үзүүлсний төлөө авахаар хөрөнгө итгэмжлэх гэрээнд заасан хөлсийг итгэмжлэгчээс шаардах;
- 3.2 Итгэмжилсэн хөрөнгийг ашигласантай холбоотойгоор гарсан зайлшгүй зардлыг итгэлцлийн хөрөнгөөс гаргуулах;
- 3.3 Хөрөнгө итгэмжлэх гэрээтэй холбоотой гарсан аливаа маргааны талаар шүүхэд нэхэмжлэл гаргах;
- 3.4 Итгэмжилсэн мөнгөн хөрөнгийг өөрийн үйл ажиллагаанд эзэмшин, ашиглаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх;
- 3.5 Итгэмжлэгчийн мөнгөн хөрөнгө, түүний үр шимийг гэрээнд заасан нөхцлөөр буцаан олгох
- 3.6 Итгэмжлэгдсэн хөрөнгийг ашгийг тооцоон бодож, олгох;
- 3.7 Итгэмжлэгчийн нууцыг хадгалах;
- 3.8 Өөрийн буруугаас учруулсан хохирлыг нөхөн төлөх;
- 3.9 Хөрөнгө итгэмжлэх гэрээгээр тохиролцсоны дагуу итгэмжлэгч буюу хувь хүртэгчид ашиг /үр шим/-ийг хүртээх;
- 3.10 Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг нэг талын санаачилгаар өөрчлөх, хугацаанаас өмнө цуцлахгүй байх;
- 3.11 Итгэмжилсэн хөрөнгө, түүний үр шимийн талаарх мэдээллийг итгэмжлэгчийн хүсэлтийн дагуу тухай бүрд нь гаргаж өгөх;
- 3.12 Итгэмжилсэн хөрөнгө хууль ёсны болох талаарх баримт бичиг, мэдээлэл өгөхийг итгэмжлэгчээс шаардах;
- 3.13 Хуульд заасан бусад эрх, үүрэг.

Дөрөв. Итгэмжлэгчийн эрх, үүрэг

- 4.1 Итгэмжилсэн хөрөнгөнд гэрээнд заасан хувиар үр шим хүртэх;
- 4.2 Итгэмжилсэн хөрөнгийг захиран зарцуулах үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох бүртгэл тайлан мэдээг шаардах;
- 4.3 Хөрөнгө итгэмжлэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах тухай санал гаргах;
- 4.4 Харилцагчийн баримт бичиг, түүний үнэн зөв хуулбарыг Итгэмжлэгдэгчид гаргаж өгөх;
- 4.5 Гэрээний дагуу итгэмжлэгдэгчид шилжүүлж байгаа мөнгөн хөрөнгө нь хууль ёсны болохыг нотлох баримтыг гаргаж өгөх, энэ талаар үнэн зөв мэдээлэл өгөх;

- 4.6 Хөрөнгө итгэмжлэх гэрээнд заасан хөрөнгийг итгэмжлэгдэгчийн удирдлагад шилжүүлэх;
- 4.7 Хөрөнгө итгэмжлэх гэрээнд заасан хөлсийг итгэмжлэгдэгчид төлөх;
- 4.8 Итгэлцлийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой итгэмжлэгдэгчээс гарсан зайлшгүй зардлыг төлөх;
- 4.9 Итгэмжилсэн хөрөнгийн ашиглалтын талаар хөрөнгө итгэмжлэх гэрээнд зааснаас өөр аливаа зааварчилгаа өгөхгүй байх;
- 4.10 ББСБ-аас үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс учирсан хохирлыг арилгуулахаар шаардах, шүүхэд нэхэмжлэх.
- 4.11 ББСБ-тай харилцах итгэмжлэгдсэн төлөөлөгч өөрчлөгдсөн даруйд энэ талаар ББСБ-д нэн даруй бичгээр мэдэгдэх, ийнхүү мэдэгдээгүйгээс үүдэн гарах үр дагавар, хариуцлагыг хүлээх, ББСБ болон итгэмжлэгчид учирсан хохирлыг хариуцах;
- 4.12 ББСБ-аас олгосон үр шимийн төлбөр, тооцоог нийлж баталгаажуулах;
- 4.13 Хуульд заасан бусад эрх, үүрэг.

Тав. Хариуцлага

- 5.1 ББСБ гэрээний 2.2.1 хэсэгт заасан үүргээ гүйцэтгээгүй бол итгэмжлэгчид гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс хоног тутамд 0.1 хувийн алданги төлнө.
- 5.2 Итгэмжлэгч хууль буюу гэрээнд заасан үүргээ зөрчсөнөөс ББСБ-д хохирол учруулбал уг хохирол, зардлыг бүрэн хариуцна.
- 5.3 Итгэмжлэгчийн өөрийн буруутай үйл ажиллагаанаас болж төлбөр тооцоо саатсан, хохирол, зардал учирснаас үүдэн гарах хариуцлагыг ББСБ хүлээхгүй.

Зургаа. Маргаан шийдвэрлэх

- 6.1 Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх аргаар шийдвэрлэнэ.
- 6.2 Хэрэв 6.1-д заасан аргаар маргааныг шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын Шүүхээр шийдвэрлүүлнэ.

Долоо. Бусад зүйл

- 7.1 Энэхүү гэрээ нь талуудын бүрэн эрхт төлөөлөгчид гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 7.2 Гэрээг хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь адил хүчинтэй байна.
- 7.3 Энэхүү гэрээний дагуу мөнгөн хөрөнгийг ББСБ-д шилжүүлэн захиран зарцуулахыг үүгээр зөвшөөрч байна.
- 7.4 Гэрээний хугацааг итгэмжлэгч ББСБ-тай гэрээ байгуулж, мөнгөн хөрөнгийг оруулсан үеэс эхлэн тооцно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ББСБ-ийг төлөөлж:

Итгэмжлэгчийг төлөөлж:

Гүйцэтгэх захирал

Иргэн:

Гарын үсэг

Гарын үсэг

Утасны дугаар:

Утасны дугаар: